МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 31

"ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХАД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАХ НЬ" СЭДЭВТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА



Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Монголын Хуульчдын холбоотой хамтран их, дээд сургуулийн оюутнуудын дунд "Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах нь" сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зарлаж байна.

Уралдаан хоёр үе шаттай зохион байгуулагдах бөгөөд оюутнууд Та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна.

Илтгэлийг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр gpo_tri@prosecutor.mn хаягаар хүлээж авна.

"ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХАД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАХ НЬ" СЭДЭВТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зорилго

Монгол Улсад Прокурорын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 95 жилийн ойг тохиолдуулан их, дээд сургуулийн оюутнуудын дунд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх оюутнуудын санал, санаачилгыг дэмжих, тэдэнд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, прокурорын хяналтын ажлын онцлогийг таниулахад оршино.

Зохион байгуулагч

- Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн
- Монголын Хуульчдын холбооны Прокурорын хороо

Илтгэлийн шалгаруулалт

1. Уралдааныг их, дээд сургуулийн оюутнуудын дунд 2025 оны 05 дугаар сарын 01, 15-ны өдрүүдэд хоёр үе шаттай зохион байгуулна.
2. Илтгэлийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр gpo_tri@prosecutor.mn хаягаар хүлээж авна.
3. Эхний шатанд ирсэн илтгэлүүдтэй зохион байгуулагчид танилцаж, шаардлага хангасан 8 илтгэлийг шалгаруулна.
4. Шалгарсан илтгэлүүдийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн танхимд хэлэлцүүлэх ба илтгэл ирүүлсэн профессор багш, оюутнуудыг тус хэлэлцүүлэгт урилгаар оролцуулна.
5. Илтгэл хэлэлцүүлэх үндсэн хугацаа 15 минут, асуулт, хариултын хугацаа 5 минут байна.

Илтгэлд тавигдах шаардлага


1. Сэдвийн хүрээнд судалгаа хийж, судалгааны үр дүнд нөхцөл байдлыг тодорхойлж, шинэлэг санал, шийдлийг дэвшүүлсэн байх;
2. Дэвшүүлсэн шийдэл, саналыг практикт хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлсэн байх;
3. Илтгэл нь эрдэм шинжилгээний бичвэрийн нийтлэг шаардлагыг хангасан байх;
   - Зохиогчийн эрхийг зөрчөөгүй, бусдын бүтээлийг хуулбарлаагүй, өмнө нь мэргэжлийн сэтгүүл, ном, хэвлэл, цахим орчинд нийтлэгдээгүй байх;
   - Хураангуй, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, эх сурвалжийн жагсаалт гэсэн бүтэцтэй байх;
   - А4 цаасан дээр 8-10 нүүрэнд багтсан, мөр хоорондын зай 1.15; үсгийн хэмжээ 12; Arial фонтоор /MS Word/ бичигдсэн байх;
   - Иш татсан ном зохиол, бүтээл, судалгаа, эх сурвалжийг тодорхой дурдсан байх.
4. Илтгэлийн зохиогч нь нэг буюу хоёр оюутан байж болох ба зохиогчийн овог, нэр, сургуулийн нэрийг илтгэлийн эхний нүүрэнд бичсэн байна. Илтгэлийг профессор багшийн удирдлага дор бичиж болно.

Шагналын сан

I байр:	-Өргөмжлөл, 500,000₮ /таван зуун мянган төгрөг/
II байр:	-Өргөмжлөл, 400,000₮ /дөрвөн зуун мянган төгрөг/
III байр:	-Өргөмжлөл, 300,000₮ /гурван зуун мянган төгрөг/
Тусгай байр:	-Өргөмжлөл, 200,000₮ /хоёр зуун мянган төгрөг/

Илтгэл хэлэлцүүлсэн оюутнуудад өргөмжлөл гардуулна.

Холбогдох мэдээлэл авах утас, хаяг:
Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн
Холбогдох утас: 99179610; 99172784
E-mail: gpo_tri@prosecutor.mn



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/722